

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2013 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилж, шүүхийн шинэтгэлийн хүрээнд батлагдсан шүүхийн тухай багц хуулийг 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс даган мөрдөж, бүх шатны шүүхэд шинэтгэлийн ажил ид өрнөж байна.

Бид өнгөрсөн хугацаанд Шүүхийн тухай багц хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн болон багц хуулийн хэрэгжилтийн бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хангах, шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх, шүүгчдийг мэргэшүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, бэхжүүлэх энэ талаар олон нийтэд сурталчлан таниулах зэрэг тодорхой зарим арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэх зорилтыг тус тус дэвшүүлэн ажилласан бөгөөд энэ чиглэлүүдэд зарим тодорхой үр дүн, ахиц гарсан нь Та бүхний идэвхи оролцоо, зүтгэл, санал санаачлага чухал байсныг цохон тэмдэглэе.

2013 онд Та бидний хөдөлмөр зүтгэлийг төр өндрөөр үнэлж, Үндэсний их баяр наадам, Тулгар төр байгуулагдсаны **2222** жил, Их Монгол Улс байгуулагдсаны **807** жил, Ардын хувьсгалын **92** жил, Их эзэн Чингис хааны хааны мэндэлсний **851** жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн ажлын албаны дарга М.Дамирансүрэн “**Монгол Улсын Гавъяат хуульч**” цолоор, мөн Шүүхийн Ерөнхий зөвлөлийн **20** жилийн ойг тохиолдуулан шүүгч Б.Батцэрэн, Х.Эрдэнэсүвд нарыг “**Шүүхийн тэргүүний ажилтан**” тэмдэгээр, шүүгч Ц.Амарсайхан, А.Доржготов, Т.Уранцэцэг, Ц.Сумъяа нарыг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн “**Хүндэт тэмдэг**”-ээр тус тус шагнагдлаа.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “**Улсын Дээд шүүх нь Ерөнхий шүүгч, хорин дөрвөөс доошгүй шүүгчээс бүрдэнэ.**” гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 47 дугаар зарлигаар **Мишигийн Батсуурь, Батаагийн Батцэрэн, Дамдины Ганзориг, Дашдоржийн Мөнхтуяа, Готовдоржийн Цагаанцоож, Дашхүүгийн Цолмон, Баттогоогийн Цогт, Хуушааны Эрдэнэсүвд** нарыг Улсын Дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томиллоо.

Шүүхийн захиргааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасны дагуу Хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс **Дашзэвэгийн Эрдэнэчулууныг**, Давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс **Дамдинсүрэнгийн Дамдин-Одыг**, Анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс

Жанчивсүрэнгийн Эрдэнэчимэгийг, Хууль зүйн яамнаас **Нанзаддоржийн Лүндэндорж** нарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилуулахаар тус тус нэр дэвшүүлэн санал болгосныг Монгол Улсын Ерөнхийлөгч 2013 оны 63 дугаар зарлигаараа нэр бүхий **4** хүнийг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүнээр, **Нанзаддоржийн Лүндэндоржийг** 2013 оны 64 дүгээр зарлигаараа Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргаар тус тус томилжээ.

Түүнчлэн Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүнд анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэр дэвшсэн **Норлоогийн Эрдэнэцогт, Намжилын Чинбат, Дуламын Пунцаг,** Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэр дэвшсэн **Хуягийн Номингэрэл, Оюунсайханы Алтангэрэл, Төмөрбаатарын Бат-Өлзий** нарыг Монгол Улсын Ерөнхийлөгч 2013 оны 83 дугаар зарлигаараа томилсон байна.

2013 онд бид дараах бүтээлийг эрхлэн хэвлүүлж, нийтийн хүртээл болгожээ. Тухайлбал:

- “Эрүүгийн эрх зүй” сургалтын гарын авлага;
- “Худалдааны эрх зүй” сургалтын гарын авлага;
- “Оюуны өмчийн эрх зүй” сургалтын гарын авлага;
- “Шүүхийн 2012 оны ажлын тайлан”;
- “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” сургалтын гарын авлага;
- “Захиргааны хэрэг эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл”;
- “Захиргааны процессийн эрх зүйн болон нэр томъёоны тайлбар”

зэрэг болно. Танхимууд болон бусад байгууллага, судлаачидтай хамтран “Процессын эрх зүй: Онол, туршлага” бүтээлийг боловсруулан хэвлэлтэд шилжүүлжээ. Мөн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар ном”, “Иргэний хуулийн 3 дугаар дэд хэсгийг тайлбар”-ыг судлан бүтээж, хэвлүүлэхэд бэлэн болгосон байна. Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын шүүн таслах ажиллагааны дүн мэдээ болон Танхимууд, Тамгын газрын тайлан гарлаа.

Ингээд Улсын Дээд шүүхийн **2013** оны ажлын **тайланг** товч танилцуулъя.

Улсын Дээд шүүхийн эрүү, иргэний болон захиргааны хэргийн тамхимуудын 2013 онд хүлээж авсан хэргийг өмнөх оны хэрэгтэй харьцуулбал:




Хүлээж авсан эрүүгийн хэрэг өмнөх оноос **358** хэрэг буюу **34,1** хувиар буурч, иргэний хэрэг **32** хэрэг буюу **3,3** хувиар, захиргааны хэрэг **48** хэрэг буюу **17,1** хувиар тус тус өсчээ.

2013 онд шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэргийг өмнөх оны хэрэгтэй харьцуулбал:



Шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос **322** хэрэг буюу **37,6** хувиар буурч, иргэний хэрэг **6** хэрэг буюу **0,8** хувиар, захиргааны хэрэг **33** хэрэг буюу **13,5** хувиар тус тус өсчээ.

Улсын Дээд шүүхийн нэг шүүгчид ногдох хэргийн ажлын ачааллыг өмнөх онтой харьцуулбал:




Нэг шүүгчид ногдох хэргийг өмнөх оны хэрэгтэй харьцуулахад эрүүгийн хэргийн танхимын шүүгч **124** хэрэг буюу **59** хувиар, иргэний хэргийн танхимын шүүгч **70** хэрэг буюу **34,4** хувиар, захиргааны хэргийн танхимын шүүгч **15** хэрэг буюу **26,8** хувиар тус тус буурсан байна.

Нэг. Шүүн таслах ажиллагааны талаар


Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны болон шүүгчдийн зөвлөгөөн:

2013 онд шүүхийн тухай багц хууль хэрэгжиж эхлэхээс өмнө нийт шүүгчдийн хуралдааныг 3 удаа зарлан хуралдуулж, 6 тогтоол гаргасны дотор эрүүгийн хэрэг 4, бусад асуудлаар 2, шүүхийн тухай багц хууль хэрэгжиж эхэлсний дараа шүүгчдийн зөвлөгөөнийг 3 удаа зарлан хуралдуулж, 4 асуудал хэлэлцэж, 4 тогтоол гарган тус тус шийдвэрлэсэн байна.

Нийт шүүгчдийн хуралдааны болон шүүгчдийн зөвлөгөөний үзүүлэлт




Нийт шүүгчдийн хуралдааны болон шүүгчдийн зөвлөгөөний 2012, 2013 оны харьцуулалт



1.1. Эрүүгийн хэргийн танхим.

Эрүүгийн хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл 40 хэрэг дээр хяналтын шатны журмаар эрүүгийн 579, цагаатгалын 72, нийт 691 хэрэг хүлээн авч, 463 эрүүгийн, 72 цагаатгалын буюу нийт 535 хэргийг шүүх хуралдаанаар хянаж шийдвэрлэж, 74 хэргийг хянан буцааж, 76 хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, одоо Эрүүгийн хэргийн танхимд 5, Ерөнхий шүүгчийн ажлын албанд 1, нийт 6 хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан эрүүгийн 691 хэргээс



Эрүүгийн хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт 65 өдөр хуралдаж, өдөрт дунджаар 8.2 хэрэг хэлэлцжээ.


Хяналтын журмаар хэлэлцэгдсэн эрүүгийн 535 хэргийн 50.1 хувь буюу 268 хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, 34.2 хувь буюу 183 хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгож, 15.7 хувь буюу 84 хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан байна.

Өөрчлөлт оруулсан 84 тогтоол, магадлалын 64.3 хувь буюу 54 нь Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, 20.2 хувь буюу 17 нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, 5.9 хувь буюу 5 шийтгэх тогтоол, магадлалд бусад өөрчлөлт оруулсан, 4.8 хувь буюу 4 нь Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж хорих ял оногдуулахаар өөрчилсөн, 2.4 хувь буюу 2 нь хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн, 2.4 хувь буюу 2 нь хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн байжээ.

Хүчингүй болгосон **183** тогтоол, магадлалын **44.8** хувь буюу **82** хэргийг (үүнээс **72** нь цагаатгалын хэрэг) **хэрэгсэхгүй** болгож, **41.0** хувь буюу **75** хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр **прокурорт** буцааж, **10.9** хувь буюу **20** хэргийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгож, **2.8** хувь буюу **5** хэргийг **шүүхээр дахин хэлэлцүүлэхээр** буцааж, **0.5** хувь буюу **1** хэргийн шийтгэх тогтоол, магадлалын зарим заалтыг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

Хяналтын журмаар Танхимын тэргүүн С.Нямжав **41**, шүүгч Д.Эрдэнэбалсүрэн **110**, Б.Бат-Эрдэнэ **109**, Т.Уранцэцэг **108**, Д.Ганзориг **71**, Б.Батцэрэн **70**, Б.Цогт **60**, Х.Батсүрэн **45**, Ерөнхий шүүгчийн ажлын алба **77** эрүүгийн хэрэг тус тус **хүлээн авчээ**.

Шүүгч тус бүрийн болон Ерөнхий шүүгчийн ажлын албаны хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн С.Нямжав **464**, шүүгч Д.Эрдэнэбалсүрэн **461**, Б.Бат-Эрдэнэ **447**, Т.Уранцэцэг **431**, Д.Ганзориг **374**, Б.Цогт **310**, Б.Батцэрэн **307**, Х.Батсүрэн **207** удаа **оролцсоноос**;

Танхимын тэргүүн С.Нямжав **426**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **55**, Т.Уранцэцэг **23**, Д.Эрдэнэбалсүрэн **21**, Б.Батцэрэн **5**, Х.Батсүрэн **5** удаа шүүх хуралдааныг **даргалж**;

Танхимын тэргүүн С.Нямжав **38**, шүүгч Т.Уранцэцэг **101**, Д.Эрдэнэбалсүрэн **92**, Б.Бат-Эрдэнэ **90**, Д.Ганзориг **60**, Б.Батцэрэн **59**, Б.Цогт **52**, Х.Батсүрэн **43** хэргийг **илтгэсэн** байна.

Эрүүгийн хэргийн танхимын шүүгчдийн 2013 оны ажлын ачаалал



Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн цагаатгалын **98** хүнд холбогдох **72** хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгон тэднийг цагаатгаж шийдвэрлэжээ.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **73.3** хувь буюу **392** хэрэг нь ялтан, өмгөөлөгч, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгчийн **гомдлоор**, **18.5** хувь буюу **99** хэрэг прокурорын **дүгнэлтээр**, **8.2** хувь буюу **44** хэрэг нь улсын яллагчийн **эсэргүүцлээр** хэлэлцэгджээ.

Тайлангийн хугацаанд Танхимын тэргүүн С.Нямжав **3**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **19**, Д.Эрдэнэбалсүрэн **18**, Д.Ганзориг **11**, Б.Батцэрэн **9**, Т.Уранцэцэг **7**, Б.Цогт **5**, Х.Батсүрэн **2** хэргийг тус тус хянан, дээд шатны прокурор эсэргүүцлээ татан авч, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохих заалтуудыг зөрчсөн эсвэл гомдол гаргах хугацаа хэтэрсэн гэсэн үндэслэлүүдээр, мөн Ерөнхий шүүгчийн ажлын алба **73** хэргийг хянан зохих хариуг өгөх байдлаар тус тус буцаасан байна.

Тус танхим 2013 онд нийт **98** албан бичиг, **101** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн С.Нямжав **119**, шүүгч Д.Ганзориг **30**,

Д.Эрдэнэбалсүрэн **24**, С.Батдэлгэр **11**, Т.Уранцэцэг **6**, Б.Цогт **3**, Б.Бат-Эрдэнэ **2**, Б.Батцэрэн **2** албан бичиг, өргөдөл гомдлыг тус тус хянан шийдвэрлэж, одоо **2** өргөдлийн үлдэгдэлтэй байна.

Шүүхийн тухай багц хууль үйлчилж эхлэхээс өмнө Хяналтын шатны **Иргэний** хэргийн шүүх хуралдааны бүрэлдэхүүнд Танхимын тэргүүн С.Нямжав **18**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **21**, Х.Батсүрэн **17**, Д.Эрдэнэбалсүрэн **12**, Т.Уранцэцэг **10**, удаа;

Захиргааны хэргийн шүүх хуралдааны бүрэлдэхүүнд Танхимын тэргүүн С.Нямжав **1**, шүүгч Д.Эрдэнэбалсүрэн **10**, Б.Бат-Эрдэнэ **4**, Х.Батсүрэн **4** удаа тус тус оролцжээ.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний захирамж **145** гарснаас Танхимын тэргүүний “**Шүүхийн харьяалал тогтоох тухай**” захирамж **68**, бусад захирамж **77**, “**Шүүх хуралдааныг хойшлуулсан тухай**” шүүхийн тогтоол **27** гарсан байна.

1.2. Иргэний хэргийн танхим.

Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл 26 хэрэг дээр хяналтын шатны журмаар 803, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан 141, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар 43, нийт 1013 хэрэг хүлээн авч, 759 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 149 хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, 42 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар хэлэлцэж, 33 хэргийг хяналтын журмаар хэлэлцэхээс татгалзаж, 10 хэргийн харьяаллыг тогтоож, одоо 20 хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан 1013 иргэний хэргээс



Иргэний хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт 70 өдөр хуралдаж, **өдөрт** дунджаар 11.4 хэрэг хэлэлцжээ.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн иргэний 759 хэргийн 61.2 хувь буюу 465 хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй болгож, 18.4 хувь буюу 140 хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, 13.1 хувь буюу 100 хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, 7.1 хувь буюу 54 хэргийн шийдвэрийг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгосон байна.


Өөрчлөлт оруулсан **100** шийдвэр, магадлалын **70** хувь буюу **70** хэрэг хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, **30** хувь буюу **30** хэргийг шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **140** шийдвэр, магадлалтай хэргээс **90.7** хувь буюу **127** хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, **9.3** хувь буюу **13** хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан **140** хэргийн **55** хувь буюу **77** хэргийг шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, **45** хувь буюу **63** хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн байна.

Хяналтын журмаар Танхимын тэргүүн Б.Ундрах **52**, шүүгч А.Доржготов **142**, Х.Сонинбаяр **142**, Ц.Амарсайхан **140**, Д.Тунгалаг **130**, Г.Цагаанцож **90**, Х.Эрдэнэсүвд **90**, Д.Цолмон **78** хэрэг тус тус хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Б.Ундрах **434**, шүүгч А.Доржготов **586**, Ц.Амарсайхан **552**, Х.Сонинбаяр **510**, Д.Тунгалаг **459**, Х.Эрдэнэсүвд **436**, Г.Цагаанцож **416**, Д.Цолмон **365** удаа оролцсоноос;

Танхимын тэргүүн Б.Ундрах **395**, шүүгч А.Доржготов **193**, Ц.Амарсайхан **87**, Д.Тунгалаг **65**, Х.Сонинбаяр **46**, Г.Цагаанцоож **4**, Д.Цолмон **3** шүүх хуралдааныг **даргалж**,

Танхимын тэргүүн Б.Ундрах **39**, шүүгч А.Доржготов **136**, Х.Сонинбаяр **136**, Ц.Амарсайхан **135**, Д.Тунгалаг **119**, Г.Цагаанцоож **83**, Х.Эрдэнэсүвд **80**, Д.Цолмон **73** хэргийг илтгэсэн байна.

Иргэний хэргийн танхимын шүүгчдийн 2013 оны ажлын ачаалал



Шүүхийн тухай багц хууль үйлчилж эхлэхээс өмнө Хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүх хуралдааны бүрэлдэхүүнд шүүгч Д.Тунгалаг **29**, А.Доржготов **14**, Х.Сонинбаяр **14** удаа;

Захиргааны хэргийн шүүх хуралдааны бүрэлдэхүүнд Танхимын тэргүүн Б.Ундрах **1** хэрэг **даргалж**, шүүгч А.Доржготов **1** хэрэг **илтгэж**, шүүгч Х.Сонинбаяр **15**, Ц.Амарсайхан **13**, Д.Тунгалаг **3** удаа тус тус оролцжээ.

Тус танхим 2013 онд нийт **81** албан бичиг, **62** өргөдөл гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Б.Ундрах **41** албан бичиг, **46** өргөдөл гомдол, шүүгч А.Доржготов **9** албан бичиг, **1** өргөдөл гомдол, Ц.Амарсайхан **6** албан бичиг, **2** өргөдөл гомдол, Д.Тунгалаг **6** албан бичиг, **2** өргөдөл гомдол, Х.Сонинбаяр **1** албан бичиг, **4** өргөдөл гомдол, Д.Цолмон **2** албан бичиг, **3** өргөдөл гомдол, Г.Цагаанцоож **1** албан бичиг, **1** өргөдөл гомдол, Х.Эрдэнэсүвд **2** өргөдөл гомдол

тус тус хянан шийдвэрлэж, **17** албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлүүлэхээр Тамгын газар болон бусад танхимд шилжүүлж, одоо **2** албан бичгийн үлдэгдэлтэй байна

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **405**-г гаргаснаас Танхимын тэргүүний “**Шүүх бүрэлдэхүүн томилох тухай**” **184**, “**Улсын тэмдэгтийн хураамж буцааж олгох тухай**” **177**, “**Гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай**” **13**, “**Харъяалал тогтоох тухай**” **10**, “**Гомдлыг хүлээж авахаас татгалзах тухай**” **9**, “**Гомдол гаргаагүйд тооцох тухай**” **9**, “**Хэргийн хугацаа сунгах тухай**” **2** захирамж гаргажээ.

Иргэний хэргийн танхим 2013 онд Улс төрийн намын бүртгэлийн талаар дараах ажлыг хийжээ. Үүнд:


Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дагуу тус сонгуульд **3** нэр дэвшигчийн өр төлбөргүй тухай тодорхойлолтыг гарган өгч, Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон сонгуулийн насны иргэдийн мэдээллийг улсын хэмжээнд **1974-2013** оны байдлаар гаргаж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлжээ.

Шинээр нам бүртгүүлэх болон намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хүссэн “**Монгол Ардын нам**”, “**Монгол Ардын Хувьсгалт нам**”, “**Монгол Консерватив нам**”, “**Чингис Хааны нам**”-ыг тус тус улсын бүртгэлд бүртгэхээс татгалзжээ.

1.3. Захиргааны хэргийн танхим.

Захиргааны хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл 7 хэрэг дээр хяналтын шатны журмаар 250, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан 50, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар 22, нийт 329 хэрэг хүлээн авч, 245 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, 4 хэргийг гомдол гаргаагүйд тооцож, шинээр нөхцөл байдлын улмаас хянуулах тухай 19 хэргийг шийдвэрлэж, Ерөнхий шүүгчийн ажлын албанд 50 хэргийг шилжүүлж, одоо 17 хэргийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын журмаар нийт хүлээн авсан 329 хэргээс



Захиргааны хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт 42 өдөр хуралдаж, **өдөрт** дунджаар 6.2 хэрэг хэлэлцжээ.

Захиргааны хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн 257 хэргээс нэг шүүгчид 32 хэрэг тус тус ногдож байна.

Хяналтын шатны журмаар хэлэлцэгдсэн захиргааны 245 хэргийн 71.4 хувь буюу 175 хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, 18.8 хувь буюу 46 хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, 9.8 хувь буюу 24 хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон 46 шийдвэр, магадлалтай хэргээс 56.5 хувь буюу 26 хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, 26 хувь буюу 12 хэргийн магадлал хүчингүй, шийдвэр хэвээр үлдээж, 8.7 хувь буюу 4 хэргийн


нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, **8.7** хувь буюу **4** хэргийн магадлалыг хүчингүй болгож, шийдвэрт өөрчлөлт оруулсан байна.

Өөрчлөлт оруулсан **24** шийдвэр, магадлалын **54.1** хувь **13** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **37.5** хувь буюу **9** нь хууль буруу хэрэглэсэн, **8.3** хувь буюу **2** шийдвэр, магадлалд бусад өөрчлөл оруулжээ.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай **19** хэргийн **2** хэргийн хүсэлтийг хангаж, **17** хэргийн хүсэлтийг хангаагүй байна.

Хяналтын шатны журмаар Танхимын тэргүүн О.Зандраа **9**, шүүгч Ц.Сумъяа **47**, Л.Атарцэцэг **46**, Ч.Тунгалаг **46**, П.Цэцгээ **45**, М.Батсуурь **29**, Д.Мөнхтуяа **29**, Х.Батсүрэн **28** захиргааны хэрэг тус тус хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн О.Зандраа **203**, шүүгч Ц.Сумъяа **194**, Л.Атарцэцэг **174**, Ч.Тунгалаг **174**, П.Цэцгээ **171**, Х.Батсүрэн **125**, М.Батсуурь **125**, Д.Мөнхтуяа **113**, удаа тус тус **оролцсоноос**;

Танхимын тэргүүн О.Зандраа **194**, шүүгч Ц.Сумъяа **23**, П.Цэцгээ **19**, Х.Батсүрэн **14**, Л.Атарцэцэг **8**, М.Батсуурь **3**, Ч.Тунгалаг **3** хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалж**;

Танхимын тэргүүн О.Зандраа **9**, шүүгч Ч.Тунгалаг **45**, Ц.Сумъяа **45**, Л.Атарцэцэг **44**, П.Цэцгээ **43**, Д.Мөнхтуяа **26**, Х.Батсүрэн **26**, М.Батсуурь **26** хэрэг тус тус **илтгэсэн** байна.

Захиргааны хэргийн танхимын шүүгчдийн 2013 оны ажлын ачаалал



Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **30.3** хувь буюу **78** нь нэхэмжлэгчийн, **23.7** хувь буюу **61** нь хариуцагчийн, **10.1** хувь буюу **26** нь гуравдагч этгээдийн, **27.6** хувь буюу **71** хэргийн оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн, **8.1** хувь буюу **21** нь өмгөөлөгчийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Тус танхим **2013 онд** нийт **54** албан бичиг, **39** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн О.Зандраа **24** өргөдөл гомдол, **28** албан бичиг, шүүгч П.Цэцгээ **3** өргөдөл, гомдол, **5** албан бичиг, Л.Атарцэцэг **2** өргөдөл, гомдол, **5** албан бичиг, Ц.Сумъяа **2** өргөдөл, гомдол, **4** албан бичиг, Х.Батсүрэн **2** өргөдөл гомдол, **3** албан бичиг, Д.Мөнхтуяа **2** өргөдөл, гомдол, **1** албан бичиг, М.Батсуурь **2** өргөдөл гомдол, **4** албан бичиг, Ч.Тунгалаг **2** өргөдөл, гомдол, **3** албан бичгийг тус тус хянан шийдвэрлэж, **1** албан бичгийн үлдэгдэлтэй байна.

Шүүхийн тухай багц хууль үйлчилж эхлэхээс өмнө Хяналтын шатны **Эрүүгийн** хэргийн шүүх хуралдааны бүрэлдэхүүнд шүүгч Х.Батсүрэн **205**, шүүгч Ц.Сумъяа **42**, Ч.Тунгалаг **10** удаа;

Хяналтын шатны **Иргэний** хэргийн шүүх хуралдааны бүрэлдэхүүнд Танхимын тэргүүн О.Зандраа **8**, шүүгч Ц.Сумъяа **56**, П.Цэцгээ **38**, Ч.Тунгалаг **34**, Л.Атарцэцэг **25**, Х.Батсүрэн **17** удаа оролцжээ.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол **233** гаргаснаас Танхимын тэргүүний “Шүүх бүрэлдэхүүн томилох тухай” захирамж **96**, хэргийн хугацаа сунгасан **5**, “Шүүх хуралдааныг хойшлуулах тухай” шүүхийн тогтоол **69**, “Улсын тэмдэгтийн хураамж буцаах тухай” захирамж **37**, “Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хүсэлтийг шийдвэрлэх тухай” шүүхийн тогтоол **19**, “Гомдол гаргаагүйд тооцох тухай” шүүгчийн захирамж **4**, бусад захирамж **3** гарсан байна.

Хоёр. Бусад асуудлаар

Гэмт хэргийн тухай, Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн ажлын хэсгүүдэд **Танхимын тэргүүн С.Нямжав, шүүгч Б.Бат-Эрдэнэ, Б.Батцэрэн, Д.Эрдэнэбалсүрэн** нар орж ажиллан;

Өршөөл үзүүлэх тухай хуулийн төсөлд Эрүүгийн хэргийн танхимын шүүгч нар саналаа тус тус өгчээ.

Түүнчлэн Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай, Цагдаагийн албаны тухай, Маршалын албаны тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслүүдийг боловсруулах, санал, дүгнэлт бэлтгэхэд **Эрүүгийн хэргийн танхимын шүүгч** нар оролцсон байна.

Захиргааны хэргийн Танхимын тэргүүн **О.Зандраа, шүүгч Л.Атарцэцэг** “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”, “Захиргааны хэргийн мониторинг”, шүүгч **П.Цэцгээ** “Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль”, шүүгч **Х.Батсүрэн** “Тахарын албаны тухай” хуулийн болон бусад хуулийн дэд ажлын хэсэгт ажиллажээ.

Мөн шүүгч **Д.Эрдэнэбалсүрэн** Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах, хяналт тавих, шийдвэрлэх ажлын уялдаа холбоог сайжруулах хамтарсан ажлын хэсэгт орж ажиллажээ.

Шүүгч **Б.Батцэрэн** нь Хуульчдийн Холбооны Шүүгчдийн хорооноос батлах “Шүүгчийн ёс зүйн дүрэм” боловсруулах ажлын хэсгийг ахлан ажилласан байна.

Иргэний хэргийн танхим өнгөрсөн хугацаанд **2** тойм, **7** ном гарган, **2** уулзалт, **4** ярилцлага зохион байгуулж, оролцсон байна.

Тухайлбал: Тойм, зөвлөмж хувьд:

а. “Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэгт хийсэн судалгаа, анхаарах асуудал”,

б. “Гэр бүлийн маргаантай хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар” тойм, зөвлөмж тус тус гаргажээ.

Гурав. Тамгын газрын ажлын талаар

3.1. Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах чиглэлээр:

Тамгын газар нь Шүүхийн тухай багц хууль, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тэдгээрт нийцүүлэн гарсан дүрэм, журам, заавар, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх, нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэх, Шүүхийн захиргааны тухай хуулийн **6-12** дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх талаар анхааран ажиллаж иржээ.

Авлигын эсрэг хууль, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-д заасны дагуу шүүгч, захиргааны албан хаагчдаас **“Албан тушаалтны хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг 2012** оны байдлаар шинэчлэгдсэн маягтын дахин гаргуулан авч, **25** шүүгчийн материалыг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Сахилгын хороонд, захиргааны албан хаагч **1** хүний материалыг Шүүхийн Ерөнхий зөвлөлд хүргүүлж, захиргааны албан хаагчийн **58** хүний материалыг тамгын газарт зохих журмын дагуу хадгалж, цахим хэлбэрээр шинэчлэн гаргажээ.

Мөн захиргааны албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн **19** хүний хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлгийг “Авлигатай тэмцэх газар”-т хянуулахаар хүргүүлэн холбогдох зөвшөөрлийг авчээ.

Түүнчлэн **“Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан”-г** шинэчилсэн програмын дагуу гаргаж, Төрийн албаны зөвлөлд хугацаанд нь хүргүүлсэн байна.

Тамгын газрын дэргэдэх захиргааны зөвлөл **10** удаа хуралдаж, Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **20** гаруй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэжээ.

Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **160** тушаал гаргасан байна.

“Билгийн тооллын хаврын тэргүүн сар - Цагаан сарын баяр”, “Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр”, “Хүүхдийн баяр”, “Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр”, “Их Эзэн Чингис хааны өдөр” тэмдэглэлт баярууд болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг бүх нийтийн амралтын өдөр болгосонтой холбогдуулан тухай бүр арга хэмжээг зохион байгуулж, Улсын Дээд шүүх дээр сахилга, хариуцлага, дэг журам, сонор сэрэмжийг өндөржүүлэх

зорилгоор **6** удаагийн Тамгын газрын даргын тушаалаар **9** ажилтныг хариуцлагатай эргүүлээр томилон ажиллуулжээ.

Мөн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д “Хуульч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсны дараа шүүхэд төлөөлөх эрх нээлгэхээр Улсын Дээд шүүхэд бүртгүүлж ... өмгөөлөгчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдэнэ.” мөн Улсын Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2013 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолыг үндэслэн Улсын Дээд шүүх 2013 оны 7 дугаар сарын 08-ны өдрөөс хүсэлт гаргасан хуульчдыг бүртгэж, тэдгээрт шүүхэд төлөөлөх эрхийн гэрчилгээ, үнэмлэх олгох ажиллагааг эхлүүлжээ.

Энэ хугацаанд Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн тушаалаар **1433** хуульчдад өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийг нээж, гэрчилгээ, үнэмлэх олгоод байна.

Шүүхийн багц хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан байгууллагын дотоод эрх зүйн дүрэм, журам болон ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулжээ.

Тайлангийн хугацаанд **310** өргөдөл гомдол, **573** албан бичиг, **2024** хавтаст хэрэг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж, уг албан бичгүүдийг Ерөнхий шүүгчид танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хувиарлан өгч шийдвэрлүүлсэнээс гадна **3403** албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад явуулжээ. Өмнөх онтой харьцуулахад хүлээн авсан албан бичиг **75**-аар, явуулсан бичиг **324**-өөр тус тус өсчээ.

3.2. Шүүхийн хүний нөөцийн чиглэлээр:

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Тамгын газрын дарга **Д.Эрдэнэчулууныг** Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүнээр, Ерөнхий шүүгчийн туслах-референт **С.Батгэрэлийг** Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгчээр, Танхимын тэргүүний туслах-ахлах шинжээч **М.Баясгаланг** Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн, Шүүгчийн туслах-шинжээч **Г.Солонгыг** Өмнөговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчээр тус тус томилогдож,

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн тушаалаар **Н.Түмэнбаярыг** Дотоод аудитын албаны ахлах референтийн, **Э.Энхжаргалыг** Иргэний хэргийн танхимын тэргүүний туслах-ахлах шинжээчийн, **М.Цэнгүүнийг** Тамгын газрын даргын туслах-шинжээчийн, **Ц.Амармэнд, Д.Батхуяг, Ц.Батзаяа, А.Зүмбэрэл, Г.Мөнхсайхан, Б.Нямцэрэн, Ч.Нямсүрэн, Д.Янжиндулам** нарыг Шүүгчийн туслах-шинжээчийн, Шүүхийн

статистик, тоон мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн **Д.Оюунчимэгийг** Цахим засаглал, хэвлэл мэдээлэл хариуцсан шинжээчийн, **Д.Тулгыг** Ёслол хүндэтгэл, гадаад зочны айлчлалын ажил хариуцсан шинжээчийн, **М.Оюунтунгалагыг** Мэдээлэл, лавлагааны ажил хариуцсан мэргэжилтний, **Г.Амартүвшин, Т.Болортуяа, Б.Өлзийхишиг, Б.Хүрэлтулга, И.Хажидмаа** нарыг Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга- мэргэжилтний албан тушаалд, **П.Энхтүвшинг** эмчийн, **Ж.Алтангэрэлийг** Тамгын газрын албан ажлын автомашины жолоочийн ажилд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн тус тус томилж,

Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын албаны дарга **Ж.Наранпүрэвийг** Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн, Дотоод ажил, зохион байгуулалтын асуудал хариуцсан шинжээч **Д.Отгонбаатарыг** Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах референтийн, Тамгын газрын даргын туслах-шинжээч **Б.Бямбабаатарыг** Ерөнхий шүүгчийн туслах-референтийн, Шүүгчийн туслах-шинжээч Б.Чимгээг Мэдээлэл лавлагааны ажил хариуцсан ахлах шинжээчийн, Мэдээлэл, лавлагааны ажил хариуцсан мэргэжилтэн **Т.Майцэцэгийг** Шүүгчийн туслах-шинжээчийн, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга- мэргэжилтэн **Г.Амартүвшинг** Шүүгчийн туслах-шинжээчийн албан тушаалд томилон дэвшүүлэн ажиллуулсан байна.

Тайлангийн хугацаанд **4** ажилтан төрийн өөр ажил, албан тушаалд дэвшин ажиллах болсон бөгөөд өөрийн хүсэлтээр төрийн албанаас **2** ажилтан чөлөөлөгдсөн байна.

2013 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн “Шүүхийн тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг батлах тухай” Шүүхийн Ерөнхий зөвлөлийн **08** дугаар тогтоолоор Улсын Дээд шүүхийн Тамгын газрыг **5** хэлтэс, **3** албаны бүтэцтэй, төрийн захиргаа болон үйлчилгээний ажилтнуудыг **107** орон тоотойгоор баталж, зарим албан тушаалын нэр, ангилал, зэрэглэлийг өөрчилснийг танилцуулъя:

Д /д	Албан тушаал		Ангилал		Зэрэглэл	
	Өмнө нь тогтоогдсон албан тушаал	Шинээр тогтоогдсон албан тушаал	Өмнө нь тогтоогдсон ангилал	Шинээр тогтоогдсон ангилал	Өмнө нь тогтоогдсон зэрэглэл	Шинээр тогтоогдсон зэрэглэл
1	Санхүү, хангамж, үйлчилгээний албаны дарга С.Баасанцэрэн	Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга С.Баасанцэрэн	Эрхэлсэн түшмэл	Эрхэлсэн түшмэл	AA-4	AA-4
2	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга Р.Ганпүрэв	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Р.Ганпүрэв	Эрхэлсэн түшмэл	Эрхэлсэн түшмэл	AA-4	AA-4
3	Санхүү, хангамж хариуцсан референт-ерөнхий нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг	Төсвийн асуудал хариуцсан референт-Ахлах нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг	Ахлах түшмэл	Ахлах түшмэл	AA-6	AA-6
4	Компьютерийн техник хангамжийн асуудал хариуцсан референт Э.Баярбаатар	Мэдээллийн технологи хариуцсан референт Э.Баярбаатар	Ахлах түшмэл	Ахлах түшмэл	AA-6	AA-6
5	Компьютерийн програ хангамжийн асуудал хариуцсан ахлах шинжээч С.Сундуйжав	Компьютерийн техник хангамжийн ажил хариуцсан ахлах С.Сундуйжав	Ахлах түшмэл	Ахлах түшмэл	AA-7	AA-7
6	Мэдээлэл, лавлагааны ажил хариуцсан мэргэжилтэн Б.Чимгээ	Мэдээлэл, лавлагааны ажил хариуцсан ахлах шинжээч Б.Чимгээ	Дэс түшмэл	Ахлах түшмэл	AA-10	AA-7
7	Төсвийн асуудал хариуцсан шинжээч- ня-бо Б.Хишигсүрэн	Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан шинжээч-няглан бодогч Б.Хишигсүрэн	Ахлах түшмэл	Ахлах түшмэл	AA-8	AA-8
8	Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн С.Бурмаа	Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан шинжээч С.Бурмаа	Дэс түшмэл	Ахлах түшмэл	AA-9	AA-8
9	Эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааны судалгаа хариуцсан шинжээч	Гэмт хэргийн тухай хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээч Н.Баярсүрэн	Ахлах түшмэл	Ахлах түшмэл	AA-8	AA-8

	Н.Баярсүрэн					
10	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны судалгаа хариуцсан Шинжээч Н.Мөнгөнцэцэг	Иргэний хэргийн хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээч Н.Мөнгөнцэцэг	Ахлах түшмэл	Ахлах түшмэл	АА-8	АА-8
11	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны судалгаа хариуцсан шинжээч Ш.Даваадулам	Захиргааны хэргийн хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээч Ш.Даваадулам	Ахлах түшмэл	Ахлах түшмэл	АА-8	АА-8
12	Архив, номын сан хариуцсан мэргэжилтэн Ж.Тэгшдэлгэр	Архивын ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Тэгшдэлгэр	Дэс түшмэл	Дэс түшмэл	АА-10	АА-9
Үйлчилгээний албан хаагчид						
13	Бичиг хүргэгч А.Пүрэвдулам				ТҮ-4	ТҮ-5
14	Мужаан Г.Баясгалан				ТҮ-2	ТҮ-3

Тайлангийн хугацаанд:

Шүүгч **Ц.Амарсайхан, Б.Батцэрэн, М.Батсуурь, Д.Ганзориг, Д.Мөнхтуяа, Г.Цагаанцоож, Б.Цогт, Д.Цолсон, Х.Эрдэнэсүвд**, Шүүхийн практик судлалын хэлтсийн дарга **Ч.Нямсүрэн**, Санхүү, хангамж, үйлчилгээний хэлтсийн дарга **С.Баасанцэрэн**, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга **Р.Ганпүрэв**, Шүүгчийн туслах-шинжээч **Э.Амин-Эрдэнэ, Ц.Амаргэрэл, Н.Нямдаваа, Б.Чимгээ, Д.Алтанцэцэг** нарын төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг,

Шүүгч **Х.Сонинбаяр**, Төсвийн асуудал хариуцсан референт-Ахлах нягтлан бодогч **А.Эрдэнэцэцэг**, Мэдээллийн технологи хариуцсан референт **Э.Баярбаатар**, Танхимын тэргүүний туслах-ахлах шинжээч **О.Батсүх**, Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан шинжээч-нягтан бодогч **Б.Хишигсүрэн**, Шүүгчийн туслах-шинжээч **Д.Алтанцэцэг**, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан шинжээч **С.Бурмаа** нарын зэрэг дэвийг тус тус шинээр болон нэмэгдүүлэн олгожээ.

Түүнчлэн Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр “Журам батлах тухай” тогтоолын дагуу шинэчилсэн загвараар төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх ажлыг зохион байгуулжээ.

3.3. Шүүхийн судалгааны чиглэлээр:

Тус хэлтэс нь Эрүүгийн, Иргэний болон Захиргааны хэргийн танхимуудаас ирж буй шаардлагатай судалгааг түргэн шуурхай, бодитой гаргахад анхаарч, орон

нутгийн шүүхүүдийн судалгааны арга зүй, арга, аргачлалыг сайжруулахад чиглэн ажиллажээ.

2013 онд Шүүхийн практик судлалын хэлтсээс дотоодын захиалгаар Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид-1, Шүүхийн Ерөнхий зөвлөлд-1, Эрүүгийн хэргийн танхимд-5, Иргэний хэргийн танхимд-8, Захиргааны хэргийн танхимд-1, Шүүхийн судалгааны төв болон практик судлалын хэлтэс-3, Хэвлэл мэдээллийн албанд-3 тоон болон чанарын нийт **22** судалгааг хийж гүйцэтгэжээ. Мөн төрийн байгууллагын захиалга, албан тоот, хүсэлтийн дагуу: УИХ-ын Тамгын газар, УИХ-ын гишүүдэд-3, Ерөнхийлөгчийн Тамгын газарт-2, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд-3, Засгийн газар, яам агентлагуудад-2, АНУ-ын азийн сан, Авлигатай тэмцэх газар, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан “Засаглал ил тод байдлыг дэмжих” төсөлд **1** тоон болон чанарын нийт **11** судалгааг хийж гүйцэтгэжээ.

Шүүх, шүүгчийн ажлыг дүгнэх шинэчилсэн журмын дагуу анхан болон давж заалдах шатны шүүх, шүүгчдийн ажлыг дүгнэх зорилгоор бүх шатны шүүхүүдээс ирүүлсэн материалуудтай танилцаж харьцуулан дүгнэж, дүнг нэгтгэж 2013 оны дөрөвдүгээр сарын 15-ны өдөр ажлын хэсэгт танилцуулжээ.

Практик судлалын хэлтсийн дарга Ч.Нямсүрэн “Гэмт хэргийн тухай хууль”, “Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай”, “Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай” хуулиудын төслийг бэлтгэх ажлын хэсэгт орж ажилласан байна.

Тус хэлтэс нь “Монголын төр эрх зүй”, “Улсын Дээд шүүхийн мэдээлэл” зэрэг улирал тутмын сэтгүүлийн дугааруудыг эрхлэн гаргажээ.

3.3.1. Шүүхийн статистикийн тоон мэдээ, мэдээллийн чиглэлээр:

Аймаг, Нийслэлийн шүүхүүдээс 2013 оны хагас жилийн шүүн таслах ажлын мэдээ, тайлан болон 1-3 дугаар улирлын шүүн таслах ажиллагааны танилцуулгыг гаргаж, Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын 2008 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 60 тоот тушаалаар батлагдсан “Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны албан ёсны статистик мэдээ, мэдээллийн тайланг хүргүүлэх заавар”-ын дагуу холбогдох байгууллагуудад хүргүүлжээ.

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн шинээр байгуулагдсан Мэдээлэл судалгааны төвд 2004-2013 оны анхан болон давж заалдах шатны шүүхийн статистик мэдээллийг 2013 оны 10 дугаар сарын 16-ны өдөр цахим болон цаасан хэлбэрээр хүлээлгэн өгсөн байна.

3.3.2. Эрх зүйн системчлэл, мэдээлэл зүйн чиглэлээр:

Шүүхийн практик судлалын хэлтэс нь Монгол Улсын хуулиуд, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий шүүгчийн захирамж, Монгол Улсын Дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоол, Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхимуудаас гаргасан тойм, зөвлөмж, шүүн таслах ажлын практик ач холбогдол бүхий хяналтын шатны эрүү, иргэн захиргааны болон нийт шүүгчдийн хуралдаан болон шүүгчдийн зөвлөгөөний тогтоолуудаар Улсын Дээд шүүхийн мэдээллийн “Нэгдсэн сан”-г баяжуулж, зарим эрх зүйн актуудыг албан ёсны сайт (www.Legalinfo.mn)-д байршуулжээ.

Тус хэлтэс нь Монгол Улсын хууль **174** хууль, Улсын Их Хурлын **65** тогтоол хүлээн авснаас **145** хуулийн, Улсын Их Хурлын **65** тогтоолын нэмэлт, өөрчлөлтийг хуулийн эх хувь болон Төрийн мэдээлэл сэтгүүлийн хувьд тухай бүрт баяжилт хийхийн зэрэгцээ хуулийн цахим санд өөрчлөлтийг оруулсан байна.

2011, 2012 оны Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт мөн Төрийн мэдээлэл сэтгүүлийг дугаар бүрээр товъёог үйлдэж хавтаслаж архивлах ажлыг зохион байгуулжээ.

3.3.3. Эрдэм шинжилгээ, сургалтын болон бусад ажлын талаар:

Хэлтсийн дарга Ч.Нямсүрэн төрийн болон төрийн бус байгууллагуудаас зохион байгуулсан эрдэм шинжилгээний бага хуралд **4** илтгэл хэлэлцүүлж, гадаад дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүл, эмхтгэлд **6** өгүүлэл бичиж хэвлүүлжээ.

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимтэй хамтран “Криминологи” сурах бичиг, “Гэмт явдлын судалгааны арга зүй”, “Гэмт явдлын учир шалгааныг илрүүлэх”, “Пенитенциар гэмт явдал”, “Хохирогч судлал” гэсэн 4 бүлэг, Үндсэн хуулийн Цэцийн захиалгаар “Хууль зүйн процесс: онол, практик” гэсэн бүтээлийн процессын онолын хэсэг, эрүүгийн процессын шүүхийн шат зэрэг хэсгийг бичиж, редакцийн зөвлөлд шилжүүлжээ.

Мөн гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр телевизийн нэвтрүүлэг **2** удаа, сонины ярилцлага **1** удаа өгсөн байна.

3.4. Шүүхийн санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр:

Улсын Дээд шүүх **2013** онд урсгал зардалд **2** тэрбум **165** сая төгрөг, улсын төсвөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтад **5** тэрбум **792** сая төгрөг, нийт **7** тэрбум **957** сая төгрөгийн төсөв батлагдаж, батлагдсан төсвийг зардлын ангилал тус бүрээр

зохих журмын дагуу зарцуулж, санхүүгийн мэдээ, тайланг холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь гарган өгч, ямар нэгэн байгууллага, хувь хүмүүст өр авлага гаргалгүй ажиллажээ.

Шүүгч, ажилтан, ахмадын зөвлөлийн гишүүн нийт **40** хүнд **8,100,000** /найман сая нэг зуун мянга/ төгрөгийн буцалтгүй тусламж, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тусламж, дурсгалын зүйлс **1** хүнд **27** сая төгрөгийг тус тус олгожээ.

2013 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилга, их засвар, тоног төхөөрөмж худалдан авахад шаардлагатай **5,792,000,000** /таван тэрбум долоон зуун ерэн хоёр сая/ төгрөгийн хөрөнгө батлагдсанаас тоног төхөөрөмж, их засварын зардалд **497,231,306** /дөрвөн зуун ерэн долоон сая хоёр зуун гучин нэгэн мянга гурван зуун зургаан/ төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

Улсын Дээд шүүхийн шинээр баригдах барилгын **5,180,000,000** /таван тэрбум нэг зуун наян сая/ төгрөгийг 2013 оны төсвийн тодотголын тухай хуулиар хассан тул хөрөнгө оруулалтын ажил хийгдсэнгүй.

Улсын Дээд шүүхийн шинээр томилогдсон шүүгч нарт болон захиргааны ажилтнуудад зориулан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Улсын Дээд шүүхийн албан ажлын хэрэгцээнд:

“Таван богд моторс” ХХК-иас “Тоёота Камри” маркийн **4** ширхэг суудлын автомашиныг **204,600,000** /хоёр зуун дөрвөн сая зургаан зуун мянган/ төгрөгөөр;

“М-Си-Эс” электроникс ХХК-иас компьютер, тог баригч, сүлжээний тоног төхөөрөмжийг **30,793,840** /гучин сая долоон зуун ерэн гурван мянга найман зуун дөчин/ төгрөгөөр;

“Номтын ам” ХХК-иар зарим өрөөнүүд болон Улсын Дээд шүүхийн барилгын гадна талын засварын ажлыг **61,553,105** /жаран нэгэн сая таван зуун тавин гурван мянга нэг зуун таван/ төгрөгөөр;

“Глобал телеком” ХХК-иас шүүх хуралдааны танхимд бичлэг хийх тоног төхөөрөмжүүд, хяналтын камерын систем, архивын галын дохиоллыг **47,259,809** /дөчин долоон сая хоёр зуун тавин есөн мянга найман зуун есөн/ төгрөгөөр;

“Санко Маркетинг Монголиа” ХХК-иас канон, принтерийг **14,042,055** /арван дөрвөн сая дөчин хоёр мянга тавин таван/ төгрөгөөр;

“БСБ Мебель” ХХК-иас албан тасалгааны тавилгыг **95,132,107** /ерэн таван сая нэг зуун гучин хоёр мянга нэг зуун долоон/ төгрөгөөр;

“Глобал электроникс” ХХК-иас хөргөгч, LED зурагт, агаар цэвэршүүлэгч, агаар чийгшүүлэгчийг **23,976,590** /хорин гурван сая есөн зуун далан зургаан мянга таван зуун ерэн/ төгрөгөөр;

“Эрдэнэт хивс “ХХКомпаниас хивс **18,433,800** /арван найман сая дөрвөн зуун гучин гурван мянга найман зуун / төгрөгөөр;

“Жи мобайл” ХХК-иас гар утасыг **1,440,000** /нэг сая дөрвөн зуун дөчин мянган/ төгрөгөөр;

Улсын Дээд шүүхийн сэтгүүлийн дансанд 2013 оны эхэнд **6,553,302** /зургаан сая таван зуун тавин гурван мянга гурван зуун хоёр / төгрөгийн үлдэгдэлтэй байснаас 2013 онд **1,164,400** / нэг сая нэг зуун жаран дөрвөн мянга дөрвөн зуун/ төгрөгийн орлого орж, **2,959,000** / хоёр сая ёсөн зуун тавин есөн сая /төгрөгийн зарлага гарчээ. Одоо тус дансанд **4,758,702** /дөрвөн сая долоон зуун тавин найман мянга долоон зуун хоёр /төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5. Шүүхийн хэвлэл мэдээллийн чиглэлээр:

Тус хэлтэс нь Улсын Дээд шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагаа, Шүүхийн тухай багц хуулийн хүрээнд шүүхэд хийгдэж буй өөрчлөлт, шинэчлэлийн талаар давхардсан тоогоор өдөр тутмын сонинд **188**, телевизэд **204**, радиод **81**, вэб сайтуудад **438** мэдээ, мэдээлэл бэлтгэн нийтлүүлж, нэвтрүүлжээ. Мөн телевизүүдийн урсдаг мэдээгээр давхардсан тоогоор **105** мэдээг олон нийтэд хүргэсэн байна. Үүний заримаас дурьдвал:

3.5.1. Телевизийн нэвтрүүлгийн хувьд:

Шүүхийн тухай багц хуулиудыг сурталчлах, тэдгээрийг иргэд, олон нийтэд тайлбарлан таниулах талаар **Монголын Үндэсний олон нийтийн телевиз, MN-25, Eagle, Монгол /HD/ телевизүүдээр** нэвтрүүлэг бэлтгэхэд хамтарч ажилласан байна.

Тус хэлтэс нь Монголын Үндэсний олон нийтийн телевизтэй хамтран “**Эрх зүйн хөтөч**” телесэтгүүлийг **4** дэх жилдээ амжилттай бэлтгэн явууллаа. 2013 оны байдлаар **15** нэвтрүүлгийг хамтран бэлтгэж явуулжээ. Тухайлбал,

-Анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүгч нарын **15** теле ярилцлага;

-Эрүү, иргэн, захиргааны эрх зүйн сэдвээр давхардсан тоогоор **8** жүжигчилсэн теле зохиомжийг тус тус бэлтгэжээ.

Мөн “**Монгол**” **HD** телевизийн “Энэ л асуудал” нэвтрүүлэгтэй хамтран ажиллаж, тодорхой сэдвүүдээр **5** нэвтрүүлэг бэлтгэн явуулсан байна.

3.5.2. Радиогийн нэвтрүүлгийн хувьд:

Монголын Үндэсний олон нийтийн радиогийн хууль эрх зүйн “Тод журам” нэвтрүүлэгтэй хамтран ажиллаж, Шүүхийн багц хуулиуд болон шүүхээр шийдвэрлэсэн тодорхой хэргийн шийдвэр дээр үндэслэсэн жүжигчилсэн зохиомж, тодорхой хэрэг маргааны талаар шүүгчийн ярилцлага бүхий нийт **21** нэвтрүүлгийг сонсогчдын хүртээл болгоод байна.

Түүнчлэн “Иргэний болон захиргааны эрх зүйн маргааны шалтгаан, нөхцөл, анхаарах зарим асуудлууд” сэдвээр болон Шүүхийн тухай багц хуулиуд болон шүүхийн шинэчлэлийн талаар Улсын Дээд шүүхийн болон бусад шүүхийн шүүгч, захиргааны ажилтнуудын ярилцлагыг “**Соёмбо**”, “**Тусгал**” нэвтрүүлгүүдээр тус тус олон нийтэд хүргэсэн байна.

3.5.3. Сонин, сайтын нийтлэлийн хувьд:

Шүүхийн үйл ажиллагаа, Шүүхийн тухай багц хууль, шүүхээр шийдвэрлэсэн зарим төрлийн гэмт хэрэг, цаг үеийн асуудалтай холбоотойгоор Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Танхимын тэргүүнүүд, шүүгчид, шүүхийн ажилтнууд, иргэдийн давхардсан тоогоор нийт **23** ярилцлага;

Тодорхой хэрэг маргаан, түүнийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр болон шүүхийн шинэчлэлтэй холбоотой давхардсан тоогоор **29** нийтлэл, өгүүллэг;

2012 оны бүтэн жилийн 2013 оны 1 дүгээр улирал, эхний хагас жилийн шүүн таслах ажиллагааны мэдээ зэргийг тус тус өдөр тутмын болон бусад сонин, вэб сайтад нийтлүүлсэн байна.

3.5.4. Хэвлэлийн бага хурлын хувьд:

2013 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Шүүхийн тухай багц хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор процессын хуулиудад орж буй өөрчлөлтийн талаар Улсын Дээд шүүхийн танхимын тэргүүнүүд мэдээлэл хийсэн хэвлэлийн бага хурлыг зохион байгуулжээ.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс 2013 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр “**Нээлттэй шүүх**” төслийн нээлтийн үйл ажиллагааны талаар хэвлэлийн бага хурал зохион байгуулахад хамтран ажилласан байна.

Хууль эрх зүйн чиглэлээр дагнан мэргэшиж буй сэтгүүлчдэд зориулан уламжлал болгон явуулдаг “**Шүүхийг сурвалжлах нь**” сэдэвт цуврал сургалтыг 2013 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр, 2013 оны 10 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд тус

тус зохион байгуулжээ. Мөн сэтгүүлчдийн дунд “Шүүх ба хүний эрх” сэдэвт уралдаан зарласан байна.

Түүнчлэн Улсын Дээд шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагааны талаар мэдээллүүдийг тогтмол бэлтгэн өөрийн вэб сайтдаа байршуулж, иргэд, олон нийтийг мэдээллээр хангаснаас гадна вэб сайтын зарим хэсгийн мэдээллийг шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэж байна.

Мөн тайлангийн хугацаанд өдөр тутмын сонины тойм **203**-ийг бэлтгэн Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Танхимын тэргүүнүүд болон холбогдох албан тушаалтнуудад, долоо хоногийн тойм **36**-ийг нэгтгэн Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид тус тус танилцуулжээ.

3.6. Ерөнхий шүүгчийн ажлын алба.

Тус алба нь тайлангийн хугацаанд **96** албан бичиг, **131** өргөдөл, гомдол, хүлээн авч, хуулийн хугацаанд нь хариу өгсөн байна.

Ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг үндэслэн Ерөнхий шүүгчийн ажлын алба Эрүүгийн **77**, Иргэний **149**, Захиргааны **53**, нийт **279** хэрэг хүлээн авч, Эрүүгийн **76**, иргэний **139**, захиргааны **44**, нийт **765** хавтас, **175,469** хуудас бүхий **256** хэргийг Ерөнхий шүүгчид танилцуулснаас Эрүүгийн **2** хэрэгт буюу Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.12-т заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэгдсэн Д.Пүрэвхүүд холбогдох хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлийн 284.2-т заасан “Хуулийн бүх шаардлагад нийцүүлэн, хуульд үндэслэн гаргасан тогтоолыг хууль ёсны гэж үзнэ”, мөн 346 дугаар зүйлийн 346.3-д “Хяналтын шатны шүүх хуралдааны товыг шүүгч тогтоож, талуудад мэдэгдэнэ”, 346 дугаар зүйлийн 346.2-т заасныг зөрчин “Хэргийн хугацааг сунгахгүйгээр хэрэг шийдвэрлэсэн” тул Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр,

Мөн Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3-д заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэгдсэн Ц.Сугаррагчаад холбогдох хэрэг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байхад үндэслэл муутай дүгнэлт хийж ял шийтгэсэн тул хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгуулахаар дүгнэлт бичигдсэнийг Нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд Ерөнхий шүүгчийн дүгнэлтийг хүлээн авсан байна.

Харин дүгнэлт бичигдээгүй **257** хэрэгт гомдол гаргасан **306** иргэн, албан тушаалтанд зохих хариуг өгсөн байна. Албан бичгээр өгсөн хариуг үл зөвшөөрч дахин гаргасан **19** гомдлыг Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2012 оны 57-р

захирамжид батлагдсан “Улсын Дээд шүүхийн хэрэг болон иргэд болон хуулийн этгээд, хэргийн оролцогчдоос гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, хуваарилах, шийдвэрлэх журам”-ын 12.2-т зааснаар Ерөнхий шүүгчид дахин танилцуулж, улмаар Тамгын газрын дарга судлан хариу өгч, гомдол материалыг буцаасан байна.

Өмнөх онтой харьцуулахад Эрүүгийн хэрэг **4-өөр** Иргэний хэрэг **19-өөр**, Захиргааны хэрэг **3-аар** тус тус буурсан байна.

2013 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар Эрүүгийн **1**, Иргэний **10**, Захиргааны **7**, нийт **18** хэрэг, **6** өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна.

Ажлын албаны дарга, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан шинжээчийг байлцуулан хэргийн оролцогчид болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч **178** хүнийг сар бүрийн **4** дүгээр **7** хоногийн **пүрэв** гарагт болон хөдөө орон нутгаас ирсэн иргэдийг тухайн өдөрт нь хүлээн авч уулзан санал хүсэлтийг нь сонсож, тэдний санал, хүсэлтийг Ерөнхий шүүгчид тухай бүрт нь танилцуулж, зохих хариуг өгчээ.

Ерөнхий шүүгчид хандаж гаргасан гомдлын дагуу эрүү, иргэн, захиргааны хэргийг хянах явцад шүүх, шүүгчдийн болон захиргааны ажилтнуудын гаргасан алдаа, зөрчилд анхаарах асуудлаар тусгайлан бүртгэл хөтөлж, давхардсан тоогоор **21** шүүгч, **63** ажилтанд энэ талаар мэдэгдэж, зөвлөмж өгч ажиллажээ.

Улсын Дээд шүүх 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2013 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хооронд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн цагаатгалын үнэмлэх олгох талаар хэлмэгдэгчдийн төрөл садан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссуудаар дамжуулан **63** өргөдөл, хүсэлтийг хүлээн авч **17031-17055** дугаартай **25** үнэмлэх шинээр олгож, **899, 10924, 10925, 6545, 4556, 4415, 15508, 5680, 5705, 1264, 391, 16908, 1490, 12784** дугаартай **14** үнэмлэхийг нөхөн олгожээ.

3.7. Шүүхийн Гадаад арга хэмжээний чиглэлээр:

Шүүхийн гадаад харилцаа жилээс жилд өргөжин тэлж шүүгч, ажилтнууд тив дэлхийн болон олон улсын бүсийн чуулга уулзалт, эрдэм шинжилгээний бага хуралд оролцож шүүн таслах ажиллагааны талаарх туршлага судлах ажил өргөжсөөр байна.

Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Зориг тэргүүтэй төлөөлөгчид Вьетнам Улсын Хо Ши Мин хотноо 2013 оны 1 дүгээр сарын 18-27-ний өдрүүдэд зохион байгуулж явуулсан “**Ази, Номхон далайн орнуудын шүүх засаглалын чадавхийг**

бэхжүүлэх нь” сэдэвт бага хуралд оролцож **“Монгол Улсад өрнөж буй шүүхийн шинэчлэлийн ач холбогдлын талаар”** сэдэвт,

Нийслэлийн шүүхийн шүүгч Ч.Хосбаяр, Увс аймгийн Сум дундын шүүхийн шүүгч Н.Гэрэлтуяа нарыг Кыргыз Улсын Бишкек хотноо тус Улсын Дээд шүүх, Европын сэргээн босголт, хөгжлийн банктай хамтран 2013 оны 3 дугаар сарын 12-16-ний өдрүүдэд зохион байгуулж явуулсан **“Азийн бүсийн орнуудын шүүхийн шинэтгэлийг бэхжүүлэх нь”** сэдэвт;

Улсын Дээд шүүхийн шүүгч Л.Атарцэцэг ОХУ-ын Владивосток хотноо Арбитрын Дээд шүүхээс 2013 оны 9 дүгээр сарын 18-21-ний өдрүүдэд зохион байгуулж явуулсан **“Татварын эрх зүй орчин үеийн эдийн засгийн харилцааны үндэс суурь болох нь”** сэдэвт олон улсын чуулга уулзалтад оролцож, **“Монгол Улсын татварын өнөөгийн эрх зүйн орчин, тулгамдаж буй асуудал”** сэдэвт;

Улсын Дээд шүүхийн шүүгч Б.Цогт Тайланд Улсын Бангкок хотноо 2013 оны 11 дүгээр сарын 18-наас 12 дугаар сарын 04-ний өдрүүдэд тус улсын Чайн Май их сургуулиас зохион байгуулж явуулсан **“Хүний наймааны золиослогчдийг буцаах, эх оронд нь ирүүлэх, иргэншлийн асуудлыг сэргээх зэрэг чадавхийг бэхжүүлэх нь”** сэдэвт;

Улсын Дээд шүүхийн шүүгч Д.Цагаанцоож Турк Улсын Истамбул хотноо тус Улсын Дээд шүүх, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран 2013 оны 11 дүгээр сарын 18-22-ний хооронд зохион байгуулж явуулсан **“Шүүхийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох нь”** сэдэвт Ази, Номхон далайн орнуудын Дээд шүүхүүдийн өндөр хэмжээний уулзалтад оролцож, **“Монгол Улсын шүүхийн шинэчлэл, цаашдын зорилт”** сэдэвт;

Мөн Улсын Дээд шүүхийн шүүгч Д.Мөнхтуяа Сингапур Улсад 2013 оны 7 дугаар сарын 8-12-ний өдрүүдэд зохион байгуулсан **“Шүүх засаглалын хөтөлбөр”** сэдэвт;

Улсын Дээд шүүхийн шүүгч М.Батсуурь Тайланд улсын Бангкок хотноо НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газартай хамтран 2013 оны 7 дугаар сарын 11-13 өдрүүдэд зохион байгуулж явуулсан **“Шүүхийн шударга ёс”** сэдэвт;

Нийслэлийн шүүхийн шүүгч Т.Өсөхбаяр, Баянгол дүүргийн шүүхийн шүүгч Г.Даваадорж нар Филиппин улсын Манила хотноо Азийн хөгжлийн банкнаас 2013 оны 11 дүгээр сарын 2-6-ний өдрүүдэд зохион байгуулж явуулсан **“Байгаль орчны эрх зүй ба түүний нөхөн сэргээлт”** сэдэвт;

Улсын Дээд шүүхийн шүүгч Д.Тунгалаг 2013 оны 12 дугаар сарын 9-18-ний өдрүүдэд Энэтхэг Улсын Лакнау хотноо зохион байгуулж явуулсан **“Дэлхийн Ерөнхий шүүгчдийн 14 дүгээр бага хурал”** сэдэвт;

Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн М.Ундрах тэргүүтэй төлөөлөгчид БНСУ-ын Дээд шүүхээс 2013 оны 12 дугаар сарын 15-21-ний хооронд зохион байгуулж явуулсан **“Дээд шүүхийн шүүгчдийн сургалт-хөтөлбөрт”** чуулга уулзалт, олон улсын бага хуралд тус тус шүүгч, захиргааны ажилтнууд оролцох ажлыг зохион байгуулжээ.

3.7.1. Гадаад айлчлалын хүрээнд:

Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Зориг, Иргэний хэргийн танхимын тэргүүн Б.Ундрах, Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа нарын тэргүүтэй төлөөлөгчид Европын холбооны сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын тусламжтайгаар хэрэгжиж буй **“Монголын шүүгчдийг худалдааны эрх зүйн чиглэлээр мэргэшүүлэх”** төслийн 1-р үе шатны хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэх, улмаар төслийг амжилттай хэрэгжүүлэхэд цаашдын хамтын ажиллагаа, сургагч шүүгч-багш нарыг цаашид хэрхэн сургах зэргийг тодорхойлсон ажлын айлчлалыг 2013 оны 2 дугаар сарын 17-23-ний өдрүүдэд Итали Улсад албан ёсны айлчлал хийжээ.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Зоригийн урилгаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Дээд Шүүхийн захиргааны Сайд Ча Хан-Сунг тэргүүтэй төлөөлөгчид 2013 оны 7 дугаар сарын 10-15-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын хүрээнд хоёр Улсын Дээд шүүхийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааг цаашид улам гүнзгийрүүлэн бэхжүүлэх зорилгоор **Монгол Улсын Дээд шүүх, Бүгд Найрамдах Солонгос Улсын Дээд шүүхийн хооронд хамтран ажиллах тухай санамж бичгийг** үзэглэсэн байна.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Зориг тэргүүтэй шүүхийн төлөөлөгчид БНХАУ-ын Ардын Дээд шүүхийн дарга, тэргүүлэгч Их Шүүгч ноён Жоу Яны урилгаар 2013 оны 8 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд БНХАУ-д албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын хүрээнд БНХАУ-ын шүүхийн салбарт хийгдэж буй өөрчлөлт, шинэчлэлтэй танилцаж, Ардын Дээд шүүх, Давж заалдах шатны шүүх болон Дайлан хотын шүүхээр зочилж, шүүхийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалсан байна.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Зоригийн урилгаар БНХАУ-ын Ардын Дээд шүүхийн шүүгч Ду Ванхуа тэргүүтэй төлөөлөгчид 2013 оны 9 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын үеэр **Монгол**

Улсын Дээд шүүх, БНХАУ-ын Дээд шүүхийн хоорондын хамтын ажиллагааны тухай санамж бичгийг үзэглэжээ

3.8. Шүүхийн сургалт, семинарын чиглэлээр:

2013 оны байдлаар Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнууд дараах сургалт, семинарыг зохион байгуулж, оролцлоо. Үүнд:

- 2013 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр Захиргааны хэргийн танхимын тэргүүн **О.Зандраа** хэвлэл мэдээллийн ажилтнууд болох сэтгүүлчдэд **“Шүүхийн тухай багц хуулийн үзэл баримтлал”, “Шүүхийн тухай хууль”, “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль”, “Шүүхийн захиргааны тухай хууль”** сэдвээр;

- 2013 оны 3 дугаар сарын 28-ны өдөр шүүгч **Д.Тунгалаг** шүүгч, хуульчдын үргэлжилсэн цагийн сургалтад **2 удаа “Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа түүний ойлголт, зарчим”** сэдвээр;

- 2013 оны 5 дугаар сарын 14-ний өдөр шүүгч **Б.Батцэрэн** Шүүхийн Ерөнхий зөвлөл, Хууль зүйн Үндэсний хүрээлэнтэй хамтран зохион байгуулж явуулсан хэвлэл мэдээллийн ажилтнууд болох сэтгүүлчдэд хуулийн мэдлэг олгох зорилгоор **“Иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн үзэл баримтлал”** сэдвээр;

- 2013 оны 6 дугаар сарын 17-30-ны өдрүүдэд шүүгч **Д.Цолмон** **“Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах”** төслийн хүрээнд Нийслэл, дүүргийн зарим шүүгч нарт **“Оюуны өмчийн эрх зүй”** сэдвээр;

- 2013 оны 6 дугаар сарын 17-22, 24-30-ны өдрүүдэд шүүгч **Д.Мөнхтуяа** Аймаг, Нийслэл, Сум, сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч нарт **“Ашигт малтмалын эрх зүй”** сэдвээр;

- 2013 оны 11 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд шүүгч **Л.Атарцэцэг, Х.Батсүрэн** нар Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн бүсчилсэн сургалтад сургагч багшаар **Төв, Хөвсгөл, Увс** аймагт зохион байгуулагдсан захиргааны хэргийн шүүхийн шүүгч, шүүгчийн туслахуудад;

Танхимын тэргүүн Б.Ундрах, шүүгч Ц.Амарсайхан, Л.Атарцэцэг, А.Доржготов, Д.Тунгалаг, П.Цэцгээ нар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын шинжээч нарт **“Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим”, “Улсын Дээд шүүхээс хууль тайлбарлах арга зүй”, “Нотлох баримтыг үнэлэхэд анхаарах асуудал”, “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ойлголт”, “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн болон шүүх хуралдааны оролцогчид, тэдгээрийн эрх зүйн байдал”, “Захиргааны**

хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах” сэдвээр;

- 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Танхимын тэргүүн **О.Зандраа** Удирдлагын академийн эрх зүйн тэнхимын багш, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тамгын ажилтан, зөвлөхүүд, судлаач нарт **“Захиргааны хэргийг урьдчилан хянан шийдвэрлэх ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд”**, **“Захиргааны акт”** сэдвээр тус тус хичээл зааж;

- 2013 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс 2 дугаар сарын 07-ны өдрүүдэд шүүгч **Л.Атарцэцэг** Америкийн Нэгдсэн Улсын Флорида мужийн Мияами хотын дэргэдэх Форт Лаудердели хотод **“Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах”** сэдэвт сургалтад;

- 2013 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн **14** хоногийн сургалтад шүүгч **Х.Сонинбаяр** Америкийн Нэгдсэн Улсын Порт лаудердель хотод **“Inlingua”** хэлний курст **14** хоногийн англи хэлний сургалтад;

- 2013 оны 3 дугаар сарын 18-ны өдрөөс 4 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэл шүүгч **Ч.Тунгалаг** Америкийн Нэгдсэн Улсын Калифорни мужид Англи хэлний сургалтад;

- 2013 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Захиргааны хэргийн танхимын шүүгч, шүүгчийн туслах-шинжээч нарт ХБНГУ-ын Баварт мужийн Захиргааны сургуулийн тэргүүн асан, доктор **Ю.Харбих** **“Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон хяналтын шатны шүүхийн үйл ажиллагаа болон нийтийн эрх зүйн хамгаалалтын талаар”** сэдэвт сургалтад;

- 2013 оны 06 дугаар сарын 03-07-ны өдрүүдэд шүүгч **Х.Сонинбаяр** Улсын Дээд шүүх болон Шүүхийн Ерөнхий зөвлөл, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн **“Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах”** төсөл хамтран **“Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн шийдвэр бичих аргачлал”** сэдэвт сургалтад;

- 2013 оны 5 дугаар сарын 27-31-ний өдрүүдэд Захиргааны хэргийн танхимын шүүгч нар Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах төсөл, Сургагч багш бэлтгэх сургалт-2 хөтөлбөрт **“Оюуны өмчийн эрх зүй”**, **“Уул уурхайн салбарын эрх зүй”**, **“Олон Улсын хувийн эрх зүйн гэрээ”**, **“Татварын маргаан”** сэдэвт сургалтад;

- 2013 оны 6 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд Захиргааны хэргийн танхимын шүүгч нар Хууль зүйн Үндэсний хүрээлэнгээс зохион байгуулж явуулсан

АНУ, БНСУ-ын хууль зүйн их сургуулиудын профессоруудын **“Хууль зүйн сургалтад Сокаратын аргыг ашиглахын ач холбогдол”** сэдэвт, **“Олон улсын арбитраж”**, профессор Чой **“Эрх зүйд захирагдах ёс ба хөгжил”**, **“АНУ-ын Үндсэн хуулийн эрүүгийн процесс”**, **“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”**, **“Бизнесийн үнэт цаас”**, **“Гэрээ ба гэрээний төсөл боловсруулах нь”** сэдэвт сургалтад;

- 2013 оны 9 дүгээр сарын 20-нд шүүгч Ц.Сумъяа, захиргааны хэргийн танхимын туслахууд **“Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн систем”** сэдэвт сургалтад тус тус хамрагдаж;

- Мөн 2013 оны 5 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулж явуулсан **“Хуулийн засаглал ба шударга ёс”** үндэсний чуулганд Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Танхимын тэргүүн, шүүгч, ажилтнууд оролцож, Захиргааны хэргийн танхимын тэргүүн **О.Зандраа “Шүүхийн шинэчлэл, цаашдын чиг хандлага”** сэдвээр, Эрүүгийн хэргийн танхимын шүүгч **Б.Батцэрэн “Эрүүгийн хариуцлагын тогтолцоо шинэтгэл”** сэдвээр, Захиргааны хэргийн танхимын шүүгч **М.Батсуурь “Монгол Улс дахь дагнасан шүүхийн тогтолцоо ба түүний үр нөлөө”** сэдвээр илтгэл хэлэлцүүлж;

- 2013 оны 5 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид **Гэмт хэргийн тухай хуулийн төслийн талаар** Хууль зүйн яам, Улсын Ерөнхий прокурорын газартай;

- 2013 оны 9 дүгээр сарын 16-наас 9 дүгээр сарын 22-ны өдрүүдэд шүүгч **Т.Уранцэцэг** Испаний Вант улсын Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дэргэдэх Шүүхийн сургуульд айлчилж, Испани болон Монгол улсын эрх зүй, шүүхийн тогтолцоо, шийдвэрлэж буй хэрэг маргааны онцлог, төрөл, шүүгдийг сонгон шалгаруулах тогтолцооны талаар;

- 2013 оны 12 дугаар сарын 18-22-ны өдрүүдэд шүүгч М.Батсуурь, Шүүхийн практик судлалын хэлтсийн дарга Ч.Нямсүрэн нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан **Төрийн хариуцлагын тухай** болон **Төрийн хяналт, шалгалтын тухай** хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтан тус газруудтай хамтарсан ярилцлага уулзалт, сургалтуудыг зохион байгуулан ажилласан байна.

Эрхэм шүүгч, ажилтнууд аа!

Улирч буй 2013 онд бид амжилт бүтээл арвин байлаа. Ирж буй 2014 он биднээс шүүхийн тухай багц хуулиудыг хэрэгжүүлэх, шүүхийн шинэчлэлийг шинэ шатанд гарган зохион байгуулах, шүүн таслах болон шүүхийн захиргааны удирдлагын шинэ бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлж ажиллах нэн хариуцлагатай, түүхэн үүргийг хүлээж байна. Тиймээс бид ирж буй жилд нөр их ажлыг амжилттайгаар гүйцэлдүүлэх шаардлагатай бөгөөд үүнд та бүхнийг идэвхи санаачлага, итгэл зүтгэл, үр бүтээл гарган ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Та бүхэндээ шинэ жилийн баярын мэнд дэвшүүлж, аз жаргал, эрүүл энхийг хүсэн ерөөе.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ
2012 оны 12 дугаар сарын 26-ны өдөр